



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамж, техникийн боломж бүрдүүлэх ажлын хүрээнд бий болсон нийт 220,000,000.00 (хоёр зуун хорин сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН "ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"  
 ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал		Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын үнэ (төгрөгөөр)
			Хэмжих нэгж	Биет хэмжээ		
1	СИП утас 0.4кВ	2020	км	5.1	11,992,500.00	61,161,750.00
2	Т/Б тулгуур	2020	ш	144	11,992,500.00	71,733,600.00
3	Тоолуур-1Ф	2020	ш	257	151,290.00	38,881,530.00
4	Тоолуурын самбар	2020	ш	88	221,400.00	19,483,200.00
5	Кабель	2020	м	485	10,147.00	4,921,295.00
6	Кабель	2020	м	8995	2,647.99	23,818,625.00
<b>Нийт дүн</b>						<b>220,000,000.00</b>
						<b>(хоёр зуун хорин сая төгрөг)</b>